



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Чулуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/018/-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.Open.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn Аудитор Н.Дашмягмар Утас: 9916-4665 Цахим хаяг: Dashmyagmarn@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 169.

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Архангай аймгийн Чулуут сумын төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй 90,444.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй. Үүнд:

1. Сумын 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 80,742.1 мянган төгрөгөөр давсан боловч 4 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 28,127.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 1 хоршоо, 5 зээлдэгчтэй холбоотой 23,904.5 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй; зэрэг нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл

олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ, ИТХ, "Чулуут ахуйн үйлчилгээний төв" ОНӨААТҮГ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна. Тус байгууллага нь орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2,459,655.3 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 2,016,712.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Чулуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 14 үндсэн зорилтын хүрээнд 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 86.4 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж олох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	837,908.35	1,041,613.23
33	МӨНГӨН ХӨРӨНГӨ	428,041.24	482,458.32
33500	АВЛАГА	271,766.56	392,688.75
33520	БАРАА МАТЕРИАЛ	107,755.55	113,127.15
35	НӨӨЦИЙН БАРАА	30,345	53,339
35400	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,643,289.3	2,738,874.92
35410	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,643,289.3	2,738,874.92
35420	Биет хөрөнгө	2,560,077.3	2,655,662.92
35440	Биет бус хөрөнгө	83,212	83,212
35600	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,481,197.65	3,780,488.14
36	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,550.38	15,497.52
36300	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,550.38	15,497.52
2	Өглөг	5,550.38	15,497.52
39	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,475,647.27	3,764,990.63
39200	Засгийн газрын хувь оролцоо	3,475,647.27	3,764,990.63
39201	Засгийн газрын оруулсан капитал	616,818.35	616,818.35
39202	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,261,748.8	1,261,748.8
39203	Эздийн өмчийн бусад хэсэг / ТӨҮГ/	19,240.89	19,240.89
39204	Хуримтлагдсан үр дүн	1,500,242.17	1,789,585.52
39205	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	77,597.06	77,597.06
39206	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,481,197.65	3,780,488.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,610,378.05	2,460,902.61
2	ТАТВАРЫН ОРЛОГО	694,813.89	725,082.39
3	Орлогын албан татвар	638,069.25	592,459.03
4	Хувь хүний орлогын албан татвар	638,052.25	621,713.45
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-29,277.72
6	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	17.00	23.3
7	Хөрөнгийн албан татвар	25,762.5	89,934.31

8	Бусад татвар, төлбөр, хураамж	30,982.14	42,689.05
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	714,195.65	1,735,820.23
10	Тусламжийн орлого	0	938,693.77
11	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,201,368.52	0
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,641,174.78	2,168,959.26
13	УРСГАЛ ЗАРДАЛ	1,618,254.78	1,871,435.53
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,562,329.16	1,858,680.13
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,934.36	945,051.68
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,406.12	118,044.71
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,753.74	368,285.84
18	Хангамж, бараа материалын зардал	93,478.82	66,551.07
19	Нормативт зардал	5,000	9,184.5
20	Эд хогшил, урсгал засварын зардал	25,837.6	49,852.7
21	Томилолт, зочны зардал	17,329	14,300
22	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,102.19	49,087.65
23	Бараа үйлчилгээний бусад зардал	254,487.33	238,321.98
24	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,925.62	12,755.4
25	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,920	297,523.73
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	969,203.27	291,943.36
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	468,010.67	0
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-468,010.67	0
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	501,192.6	291,943.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,130,675.77	2,149,398.15
2	ТАТВАРЫН ОРЛОГО	694,813.89	725,082.39
3	Орлогын албан татвар	638,069.25	592,459.03
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-29,277.72
5	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	17.0	23.3
6	Хөрөнгийн албан татвар	25,762.5	89,934.31

7	Бусад татвар, төлбөр, хураамж	30,982.14	42,689.05
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,445.1	6,758.1
9	Газрын төлбөр	1,021.61	16,652.8
10	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,515.43	19,278.16
11	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	234,493.37	1,424,315.76
12	Нийтлэг татварын бус орлого	234,493.37	192,537.01
13	Тусламжийн орлого	-	938,693.77
14	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	293,084.98
15	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,201,368.52	-
16	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,422,915.1	1,683,542.43
17	УРСГАЛ ЗАРДАЛ	1,422,915.1	1,683,542.43
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,366,189.48	1,670,787.03
19	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	751,947.54	939,127.12
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,614.12	119,528.17
21	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	290,393.4	367,464.66
22	Хангамж, бараа материалын зардал	96,184.1	65,446.58
23	Нормативт зардал	5,000	9,184.5
24	Эд хогшил, урсгал засварын зардал	48,747.6	54,191.4
25	Томилолт, зочны зардал	5,329	14,300
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,207.14	65,250.06
27	Бараа үйлчилгээний бусад зардал	46,766.58	36,294.54
28	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,725.62	12,755.4
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	707,760.67	465,855.71
30	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	551,273.79	321,438.63
31	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	551,273.79	321,438.63
32	Дотоод эх үүсвэрээр	551,273.79	321,438.63
33	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-551,273.79	-321,438.63
34	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	80,000.0	90,000.0
35	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-80,000.0	- 90,000.0
36	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	76,486.89	54,417.09
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	351,554.35	428,041.24
38	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	428,041.24	482,458.32

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,989,225.87	2,989,225.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-14,771.2	-14,771.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,974,454.66	2,974,454.66
4	Тайлант үеийн үр дүн	501,192.6	501,192.6
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,475,647.27	3,475,647.27
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,475,647.27	3,475,647.27
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,600	-2,600
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,473,047.27	3,473,047.27
9	Тайлант үеийн үр дүн	291,943.36	291,943.36
10	2025 оны 12-р сарын 01-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,764,990.63	3,764,990.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	868,288.50	844,705.79	23,582.71	97.3
11	Татварын орлого	648,183.30	725,082.39	-76,899.09	111.9
110	Орлогын албан татвар	519,273.80	592,459.03	-73,185.23	114.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	550,254.00	621,713.45	-71,459.45	113.0
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	415,600.00	461,739.09	-46,139.09	111.1
110002	Үйл ажиллагааны орлого	20,310.00	17,453.90	2,856.10	85.9
110003	Хөрөнгийн орлого	113,700.00	138,723.36	-25,023.36	122.0
110004	Хөрөнгө борлуулсны орлого	500	3,632.95	-3,132.95	726.6
110008	Шууд бус орлого	144	164.15	-20.15	114.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-31,000.00	-29,277.72	-1,722.28	94.4
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-31,000.00	-29,277.72	-1,722.28	94.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	19.8	23.3	-3.50	117.7

110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	19.8	23.3	-3.50	117.7
113	Хөрөнгийн албан татвар	103,445.50	89,934.31	13,511.19	86.9
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,007.80	8,598.81	-5,591.01	285.9
113002	Бууны албан татвар	4,230.00	4,680.00	-450.00	110.6
113004	Малд ногдуулах албан татвар	96,207.70	76,655.50	19,552.20	79.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	25,464.00	42,689.05	-17,225.05	167.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,125.40	6,758.10	1,367.30	83.2
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,919.00	1,919.10	-0.10	100.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,206.40	4,839.00	1,367.40	78.0
1181	Газрын төлбөр	1,497.60	16,652.80	-15,155.20	1112.0
118101	Газрын төлбөр	997.6	1,372.80	-375.20	137.6
118102	Дуудлага худалдаа	500	15,280.00	-14,780.00	3056.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	15,841.00	19,278.16	-3,437.16	121.7
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	9,947.50	10,382.06	-434.56	104.4
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,060.00	5,497.60	-3,437.60	266.9
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,590.00	1,155.00	435.00	72.6
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2,243.50	2,243.50	0.00	100.0
12	Татварын бус орлого	220,105.20	119,623.41	100,481.79	54.3
120	Нийтлэг татварын бус орлого	220,105.20	119,623.41	100,481.79	54.3
120003	Торгуулийн орлого	500	2,955.00	-2,455.00	591.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	218,605.20	107,507.75	111,097.45	49.2
120009	Бусад орлого	1,000.00	9,160.65	-8,160.65	916.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,459,655.30	2,016,712.93	442,942.37	82.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,839,817.93	1,638,999.27	200,818.66	89.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,823,204.43	1,626,243.87	196,960.56	89.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	922,597.70	904,177.02	18,420.68	98.0
210101	Үндсэн цалин	770,295.90	495,321.89	274,974.01	64.3
210102	Нэмэгдэл	94,420.00	365,448.59	-271,028.59	387.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,240.00	20,090.00	13,150.00	60.4
210104	Урамшуулал	24,641.80	23,316.54	1,325.26	94.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,225.60	113,499.13	1,726.47	98.5
210201	Тэтгэврийн даатгал	78,353.30	77,602.75	750.55	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,218.00	9,010.87	207.13	97.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,609.10	4,677.71	-68.61	101.5
210204	Ажилгүйдлийн даатгал	4,609.10	4,447.99	161.11	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	18,436.10	17,759.82	676.28	96.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,401.20	340,856.82	34,544.38	90.8
210301	Гэрэл, цахилгаан	119,181.20	93,968.03	25,213.17	78.8

Архангай аймгийн Чулуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	230,198.10	228,141.49	2,056.61	99.1
210303	Цэвэр, бохир ус	26,021.90	18,747.30	7,274.60	72.0
2104	Хангамж, бараа материалын зардал	84,434.60	63,128.58	21,306.02	74.8
210401	Бичиг хэрэг	17,500.00	11,204.55	6,295.45	64.0
210402	Тээвэр, шатахуун	43,189.70	34,363.15	8,826.55	79.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,692.40	6,819.19	1,873.21	78.5
210404	Ном, хэвлэл	1,779.40	743	1,036.40	41.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,206.40	5,305.70	900.70	85.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,066.70	4,693.00	2,373.70	66.4
2105	Нормативт зардал	13,000.00	9,184.50	3,815.50	70.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,000.00	9,184.50	3,815.50	70.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	144,625.10	78,417.30	66,207.80	54.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,109.00	24,089.60	21,019.40	53.4
210602	Тавилга	14,386.50	5,036.00	9,350.50	35.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000.00	-		
210604	Урсгал засвар	84,129.60	49,291.70	34,837.90	58.6
2107	Томилолт, зочны зардал	17,800.00	14,300.00	3,500.00	80.3
210702	Дотоод албан томилолт	17,800.00	14,300.00	3,500.00	80.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,679.90	67,654.02	12,025.88	84.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,229.90	66,204.02	12,025.88	84.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000.00	1,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450	450	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,325.10	34,913.00	35,412.10	49.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,000.00	20,325.00	11,675.00	63.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,325.10	14,588.00	23,737.10	38.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,613.50	12,755.40	3,858.10	76.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,613.50	12,755.40	3,858.10	76.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,613.50	9,613.40	0.10	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000.00	3,142.00	3,858.00	44.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	447,419.70	287,713.73	159,705.97	64.3
223001	Бусад хөрөнгө	447,419.70	287,713.73	159,705.97	64.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	172,532.90	90,000.00	82,532.90	52.2
230001	Эргэж төлөгдөх зээл	172,532.90	90,000.00	82,532.90	52.2
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-1,476,141.20	-1,058,394.57	417,746.63	71.7
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,476,141.20	1,058,394.57	417,746.63	71.7
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,476,141.20	1,058,394.57	417,746.63	71.7

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	427,986.39		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	482,439.27		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	3	3	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31	0.00	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,432,172	(5,432,172)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,432,172	(5,432,172)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,432,172	(5,432,172)
2104	Хангамж, бараа материалын зардал	580,000	(580,000)
210402	Тээвэр, шатахуун	580,000	(580,000)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,470,632	(3,470,632)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,470,632	(3,470,632)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,381,540	(1,381,540)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,381,540	(1,381,540)
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,432,172	(5,432,172)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,432,172	(5,432,172)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,152,172	(5,152,172)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280,000	(280,000)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт 52,031.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчил арилгуулах 2 албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 52,031.7 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн 90,444.8 мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **142,476.5** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ.

Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 32,857.4 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлээр 4 нэр төрлийн орлого 28,127.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн албан шаардлага: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогын сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3.1.2 Хоршоо хөгжүүлэх санд 5 иргэн 1 хоршоотой холбоотой 23,904.5 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 дүгээр зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС-тай холбоотой Орлоготой холбоотой	1	23,904.5	0	0	1	23,904.5						
	1	28,127.2			1	28,127.2						
Нийт дүн	2	52,031.7			2	52,031.7						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ, Чулуут ахуй үйлчилгээний төв	2	-	-	-	2	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	2	-	-	-	2	-	-	-

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

Нийт зөрчил	Үүнээс:
-------------	---------

Архангай аймгийн Чулуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын нэр			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	4	11,995.5	1	1,015.0	3	10,980.5						
ИТХ	2	4,180.0	1	3,388.0	1	792.0					-	-
АҮТ	2	72,949.3			2	72,949.3						
Эрүүл мэндийн төв /Тогтмол зардал/	1	1,320.0	1	1,320.0								
ХХС-тай холбоотой	1	23,904.5			1	23,904.5						
Орлоготой холбоотой	1	28,127.2			1	28,127.2						
Дүн	11	142,476.5	3	5,723.0	8	136,753.5						